

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар .93

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, Засгийн газрын 1995 оны 111, 2016 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Нэг талаас Сангийн яам, түүнийг төлөөлж Сангийн сайд Б.Жавхлан / цаашид “үүрэг гүйцэтгүүлэгч” гэх/, нөгөө талаас Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт/регистрийн дугаар: 8027838/, түүнийг төлөөлж тэргүүн Г. Баянмөнх /цаашид “үүрэг гүйцэтгэгч” гэх/ нар /хамтад нь “талууд” гэх/ доорх нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг / цаашид “Гэрээ” гэх / байгуулав.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1 Гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь дор дурдсан төрийн байгууллагын зарим чиг үүргийг иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай, чанартай гүйцэтгэхэд оршино.

2.1.1 Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг талууд хамtran зохион байгуулах;

2.1.2 Үнэлгээчний тусгай зөвшөөрлийг 3 хүртэл жилийн хугацаагаар сунгах, тусгай зөвшөөрлийг 3 хүртэл сарын хугацаагаар түдгэлзүүлэх, хүчингүй болгох санал, дүгнэлтийг тус тус ирүүлэх;

2.1.3 Үнэлгээчнийг бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

2.1.4 Үнэлгээний олон улсын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах, хэрэглэх, тайлбар, зөвлөмж боловсруулан гаргах;

2.1.5. Үнэлгээчний мэргэжлийн ёс зүйд суурилсан хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамtran ажиллах, мэргэжлийн ёс зүйг сайжруулах, хяналт тавих, хариуцлага тооцох, чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх.

2.2 Талууд Гэрээний 2.1.1-д заасан үйл ажиллагааг хамtran зохион байгуулна.

2.3 Үүрэг гүйцэтгэгч нь үнэлгээний олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтад хамрагдаж буй эрх горилогчдыг сургалтын материалыаар бүрэн хангаж, шалгалтад зориулсан тестийн санг бүрдүүлэх, шинэчлэхэд оролцож, үнэн зөв байдлыг хариуцна.

2.4 Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 сарын дотор энэхүү гэрээний 2.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж үүрэг гүйцэтгүүлэгчээр батлуулна.

ГУРАВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль болон энэ гэрээнд заасны дагуу явагдаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянан, арга хэмжээ авч, шийдвэр гаргах эрхтэй.

3.2 Үүрэг гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн нэг талын санаачилгаар тус гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгох бүрэн эрхтэй.

3.3 Үүрэг гүйцэтгэгчийн Гэрээнд тусгасан үүргээ гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг Гэрээнд хавсаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.4 Үүрэг гүйцэтгэгчийн Гэрээнд тусгасан үүргээ гүйцэтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж болно.

ДӨРӨВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны зохион байгуулалтад үүрэг гүйцэтгүүлэгчээс туслалцаа, дэмжлэг авах эрхтэй.

4.2 Гэрээний 2.1-д заасан чиг үүргийг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж, үүрэг гүйцэтгүүлэгчид тайлагнах үүрэгтэй.

4.3 Гэрээ болон ажлын төлөвлөгөөний биелэлтийг үүрэг гүйцэтгүүлэгчид тухайн оны 12 дугаар сарын 5-ны өдөр дотор бичгээр ирүүлж дүгнүүлнэ.

ТАВ. ТАЛУУДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээний нөгөө талаас шаардах эрхтэй.

5.2 Гэрээний биелэлтийг хангахад технологийн болон эрх зүйн орчинд өөрчлөлт шинэчлэлт гарсан тохиолдолд хамтын ажиллагааг тэдгээрт нийцүүлэх талаар санаачилга гаргаж ажиллана.

5.3 Талууд Гэрээний үүргийн биелэлтийг 12 дугаар сарын 05-ны дотор гаргаж 12 дугаар сарын 15-ны дотор дүгнэнэ.

ЗУРГАА. ДЭМЖЛЭГ

6.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь 2.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүрэг гүйцэтгэгчид олон улсын байгууллагын техник, туслалцааны төслийн шугамаар гадаад болон дотоодын зөвлөх үйлчилгээгээр хангах, дэмжлэг үзүүлэх.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн байх болзошгүй тохиолдолд илэрсэн зөрчил дутагдлыг харилцан мэдээлэх, зөрчлийг арилгах талаар хамтран ажиллана.

7.2 Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тал хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ.

8.2 Хэрэв талууд харилцан зөвшилцэж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1 Гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Гэрээг 3 хувь үйлдэж үүрэг гүйцэтгэгч тал 1 хувь, үүрэг гүйцэтгүүлэгч тал 2 хувийг тус тус хадгалах бөгөөд эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

9.3 Талууд энэхүү Гэрээгээр хүлээх эрх үүргээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусдад шилжүүлэхгүй.

9.4 Гэрээний талуудын үйл ажиллагааны чиглэл, нэр, удирдлага зохион байгуулалтад аливаа өөрчлөлт орсон тохиолдолд тухайн үйл ажиллагааг залгамжлан хэрэгжүүлэх байгууллага нь Гэрээний эрх, үүргийг шууд хүлээн авах ба Гэрээний үүрэг заавал биелэгдэх шинжтэй байна.

9.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийх бөгөөд Гэрээнд оролцогч бүх талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний нэгэн адил хүчинтэй байж, түүний салшгүй хэсэг байна.

9.6 Гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжкоор зохицуулж, түүнийг удирдлага болгоно.

9.7 Гэрээ нь гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН
ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТИЙГ
ТӨЛӨӨЛЖ:



Г.БАЯНМОНХ

БАТЛАВ. САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Болормаа

Б.БОЛОРМАА

1119289511-9131787

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТИЙН ГЭРЭЭГЭЭР
ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 3-р сарын 1..-ны өдөр

Гэрээгээр хүлээсэн чиг үүрэг	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн
2.1.1. Хөрөнгийн үнэлгээний эрх олгох сонгон шалгаруулалтыг хамтран зохион байгуулах	1.Хөрөнгийн үнэлгээчний эрх олгох сонгон шалгаруулалт болон эрх сунгах шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах.	2,4-р улирал	Эрх олгох, сунгах үйл ажиллагааг 2-оос доошгүй удаа батлагдсан журмын дагуу зохион байгуулсан байна.
	2.Эрх олгох, сунгах шалгалтын тестиийн санг хичээл тус бүрээр 100 асуулт, бодлогоор нэмэгдүүлж, шинэчлэх.	жилдээ	Шалгалтын тестиийн санг YOUC-д нийцүүлэн шинэчилсэн байна.
2.1.2. Хөрөнгийн үнэлгээчний тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох санал, дүгнэлтийг ирүүлэх	3.Хөрөнгийн үнэлгээчний тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох санал, дүгнэлтийг холбогдох материалын хамт Сангийн яаманд хүргүүлэх. Тусгай зөвшөөрлийг сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон үнэлгээчдийн талаарх мэдээллийг иргэн, олон нийтэд мэдээлэх.	6-р сард, 11-р сард	Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох 97 үнэлгээчний эрхийг сунган олон нийтэд мэдээлсэн байна.
	4.Хөрөнгийн үнэлгээчин, үнэлгээний тайлантай холбоотой төрийн болон хувийн байгууллага, шүүх, хувь хүнээс ирж буй санал, гомдлыг хүлээн авч Мэргэжлийн зөвлөл, Мэргэжлийн хариуцлагын хороогоор хэлэлцэж, холбогдох дүгнэлтийг гаргах.	Жилдээ	Ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр нь шийдвэрлэсэн байна.
	5.Гомдлыг бүртгэх, хэлэлцүүлэх зэрэг үйл ажиллагааг нь цахим хэлбэрт бүрэн оруулах.	2-р улиралд	Гомдлыг хүлээн авч бүртгэх үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн оруулсан байна.
	6.Хөрөнгийн үнэлгээний цахим мэдээллийн санг бий болгох: Үүнд: • Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчдийн мэдээллийн санг бүрдүүлэх,		Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчдийн болон хөрөнгийн үнэлгээний

	<ul style="list-style-type: none"> Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3, 27.2.4 дэх заалтыг хэрэгжүүлэн мэдээллийн санг хөгжүүлэх. 	3,4-р улиралд	мэдээллийн санг хөгжүүлсэн байна.
2.1.3. Үнэлгээчнийг бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах	<p>7. Хөрөнгийн үнэлгээний эрх олгох, эрх сунгах, мэргэшүүлэх сургалтын жишиг хөтөлбөрийг төрөлжүүлэн боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханганд ажиллах.</p> <p>7.1 Хөрөнгийн үнэлгээчнийг оюуны өмчийн үнэлгээ, ашигт малтмалын үнэлгээ, бизнесийн үнэлгээгээр мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулах.</p>	1-р улиралд 1-4-р улиралд	Шинэчилсэн жишиг хөтөлбөрөөр 4-с доошгүй удаа сургалтыг зохион байгуулсан байна. АМЕП-2 төсөл, Австралийн Уул уурхайн институт AusIMM, МОНВАЛ Хороо хамтран зохион байгуулсан байна.
2.1.4. Үнэлгээний олон улсын стандарт түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах болон хууль эрх зүйг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах	<p>8. Хөрөнгийн үнэлгээний арга аргачлалыг боловсруулан, хэлэлцүүлж санал авах ажлуудыг зохион байгуулах:</p> <ul style="list-style-type: none"> YOUC 2022 шинэчлэгдсэн стандартыг орчуулж хэвлүүлэх, Оюуны өмчийн үнэлгээний аргачлал, Ашигт малтмалын үнэлгээний аргачлалыг боловсруулах. 	1-р улиралд 4-р улиралд 1-2-р улиралд	Үнэлгээний олон улсын стандарт болон түүнд нийцсэн арга, аргачлалыг боловсруулсан байна..
	9. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ нэгдсэн болон байнгын хорооны хуралдаан, дэд ажлын хэсгийг шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр нь ханганд ажиллах	жилдээ	УИХ-ын ЭЗБХ-ноос байгуулсан ажлын дэд хэсэгт орж ажилласан байна.
	10. Санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээний талаар мэргэжлийн оролцогчдыг хамруулсан форумыг зохион байгуулна.	5-р сард	СЯ, ММНБИ, ТМУИ, МДАХ, ММУИ, салбарын оролцогчдыг хамруулсан байна.
2.1.5. Үнэлгээчний мэргэжлийн ёс зүйд суурилсан хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, мэргэжлийн ёс зүйг сайжруулах, хяналт тавих, хариуцлага тооцох, чанарын	<p>11. Мэргэжлийн ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулах.</p> <p>12. Мэргэжлийн ёс зүйг таниулан сурталчлах, ном сурх бичиг материал бэлтгэх, боловсруулах.</p> <p>13. Ёс зүйн алдаа гаргасан нь мэргэжлийн хариуцлагын хорооны дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд хариуцлага тооцох.</p>	2-р улиралд 3-р улиралд Тухай бүр нь	<p>Үнэлгээчдийн ёс зүйн дүрмийг боловсруулж, сургалтын гарын авлагыг боловсруулсан байна.</p> <p>Мэргэжлийн хариуцлагын хорооноос гаргасан дүгнэлтийн дагуу</p>

хяналтын тогтолцоог нэвтрүүлэх	14. Үнэлгээчдийн хийсэн үнэлгээний тайлан, үйл ажиллагаанд нь түүвэрчилсэн шалгалтыг хийх.	3-р улиралд	хариуцлага тооцсон байна. 30 үнэлгээчнийг хийсэн үнэлгээний тайлан, үйл ажиллагаанд нь чанарын хяналтыг хийсэн байна.
Доржсүрэн УУЧЛЫН НӨХЦӨЛ НӨХЦӨЛ НӨХЦӨЛ	Ажлыг ирснээгээ чадахаасаа нэрийнчүү дэлдэрэе тээвэр, сподор рэжис, эрэлжийн түүрүүсээ хөөд, цэсэлчилгээ үйлчилж жинхийн төслийн төслийн хөөд тийнээ	Бахчын хөөд нэхдээ	Бахчын хөөд нэхдээ
Мэдэлжин төслийн чөлөө нөхцөнчийн нэхдээ бийнээс төслийн	Цэсэлчилгээ төслийн чөлөө нөхцөнчийн нэхдээ бийнээс төслийн	Бахчын хөөд нэхдээ	Цэсэлчилгээ төслийн чөлөө нөхцөнчийн нэхдээ бийнээс төслийн
Галстайгааны А жилүүртлийн түүд сөснүүд нааныж ишигэвт нээжүүлж бийнээс нээжүүлж	Ихэвхийг шүүт	Ихэвхийг шүүт	Ихэвхийг шүүт
Нийтийн бийнээс төслийн чөлөө тийшүүтэй чадуулжүүлэх бийнээс нээжүүлж	Нийтийн шүүт	Нийтийн шүүт	Нийтийн шүүт
-1 зөвлөж жилэвэй ийнхүүкод эсэ жилүүртлийн түүд бийнээс нээжүүлж	Нийтийн шүүт	Нийтийн шүүт	Нийтийн шүүт
Ленжелж түүрүүртэй чадуулжүүлэх бийнээс	Нийтийн шүүт	Нийтийн шүүт	Нийтийн шүүт